



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017.06.22 дугаар
сарын 22 ны өдөр

Дугаар ХЭГ/1010

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ө.ЭНХТҮВШИН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сантай хамтран “Өргөтгөсөн санхүүжүүлтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тохиролцсоноос хойш авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

075227

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ө.ЭНХТҮВШИНГЭЭС ЕРӨНХИЙ САЙД
Ж.ЭРДЭНЭБАТАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

НЭГ. ОУВС-ИЙН “ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙН ТУХАЙ

Олон улсын валютын сангийн Захирлуудын зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаар манай улсад “Extended Fund Facility” буюу “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн тул Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сан /ОУВС/- гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлээд байна¹. Уг хөтөлбөр нь 3 жилийн хугацаатай бөгөөд хөтөлбөрийн хүрээнд ОУВС-аас 434.3 сая ам.долларын² санхүүжилтийг төлбөрийн тэнцлийг дэмжих зориулалтаар олгохоос эхний хэсэг болох 38.6 сая долларын санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газарт олгоод байна. Хөтөлбөрийн нийт санхүүжилт 5.5 тэрбум гаруй ам.доллар байна. Үүнээс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 15 тэрбум юаны своп хэлцлийн хугацаагаа сунгах замаар дэмжиж хамтран ажиллах бол Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллага, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг хоёр талт түншлэгч орнуудаас нийт 3 тэрбум гаруй ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг төсвийн дэмжлэг, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр олгох юм. Эдгээр төсвийн дэмжлэг, төслийн санхүүжилтийг ашиглан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл, эдийн засгийг сэргээх хөтөлбөр зэрэгт туссан эдийн засгийн төрөлжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, төсөв-мөнгөний бодлогын шинэчлэл хийх зэрэг үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

ХОЁР. ОУВС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТОХИРСОН БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭ

ОУВС-ийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр эдийн засгийг тогтворжуулж, банкны салбарыг бэхжүүлэх, дунд хугацааны тогтвортой өсөлтийн суурийг тавьж, өрийн зохистой түвшинг хангах зорилт дэвшүүлсэн. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь нэн тэргүүний зорилго бөгөөд Эдийн засагт үүссэн бүтцийн шинжтэй сул талыг арилгах замаар урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэсэн бодлогууд хэрэгжүүлэхээр тохиролцсон.

Хөтөлбөрийн хүрээнд төсвийн нэгдмэл байдлыг хадгалах, өрийн зохистой түвшинг хангах, алдагдлыг бууруулахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлэх бол макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг дэмжих, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулахад чиглэсэн Мөнгөний бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн, Банкны салбарт иж бүрэн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд бүтцийн өөрчлөлт хийх, дахин

¹ “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” нь бүтцийн алдаанаас хамаарч эдийн засгийн өсөлт саарсан, төлбөрийн тэнцэл ихээхэн хүндрэлтэй байгаа улс, орнуудад зориулагдсан бөгөөд бусад хөтөлбөрийг бодвол илүү урт хугацаанд өргөн хүрээний арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдүүлдгээрээ онцлог юм.

² Манай улсын ОУВС дахь квот нь 72.3 сая зээлжих тусгай эрх (SDR) бөгөөд үүнийг ам.долларт шилжүүлбэл 106.7 сая ам.доллар болно. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т (EFF) хамрагдсанаар квотын 435 хувь болох 434.3 сая ам.долларын санхүүжилт сангаас авах боломжтой.

хөрөнгөжүүлэх, банкуудын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгасан.

ГУРАВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд төсвийн бодлогын чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүллээ. Тухайлбал:

- Иргэдийн орлогын ялгааг бууруулах, татварын тэгш, шударга байх зарчмыг хангах зорилгоор:
 - Хувь хүний орлогын албан татварыг орлогын хэмжээнээс хамааруулж шатлалтайгаар ногдуулах, нөгөө талаас татварын хөнгөлөлтийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх,
 - Хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулах,
- Нийгэм, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг зарим төрлийн хэрэглээг хязгаарлах зорилгоор:
 - Архи, тамхины онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх,
 - Суудлын автомашины онцгой албан татварыг нэмэх,
 - Импортын тамхинд ногдох гаалийн албан татварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

(Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2017 оны эхний 5 сарын байдлаар 2.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 800 гаруй тэрбум төгрөг буюу 40 орчим хувиар өссөн, үүнд: Орлогын албан татвар 44.7 хувиар, Нэмэгдсэн өртгийн албан татвар 41.0 хувиар өссөн)

- Төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, сахилга батыг сайжруулах зорилгоор:
 - үндэсний хэмжээнд мөрдөх хэмнэлтийн хөтөлбөр боловсруулах,
 - төрийн байгууллагуудын зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг уян хатан зарцуулах журам зэргийг боловсруулж, мөрдүүлэх,

(2016 онд Гадаад албан томилолтын зардлыг 192.5 сая төгрөгөөр, 2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 8.1 хувиар, тоног төхөөрөмжийн зардлыг 15.3 хувиар бууруулсан. 2017 онд нийт зардлын хэмжээ нэмэгдсэн мэт харагдаж байгаа боловч бүтцийн хувьд задлаад үзвэл арай өөр дүр зураг харагдана. Тухайлбал, нийт зардлын 78.1 хувийг дангаараа бүрдүүлдэг урсгал зардал нийт дүнгээрээ 78.3 тэрбум төгрөгөөр буюу 1.1 хувиар буурахаар байгаа. Сүүлийн 3 жилд төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбоотойгоор төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлээгүй нь урсгал зардлын өсөлтийг хязгаарлахад гол нөлөө үзүүлсэн. Мөн тээвэр шатахуун, гадаад дотоод томилолт, харилцаа холбоо, автомашин болон тавилга эд хогшил худалдан

авах зардал дээр хатуу хяналт тогтоож хязгаарлах арга хэмжээ авсан нь нөлөөлсөн. Гэхдээ хүн амын өсөлт, валютын ханшны өөрчлөлттэй холбоотойгоор төрийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэн. Эдгээр зардлыг дээрх хүчин зүйлсийн өөрчлөлтөд нийцүүлж нэмэгдүүлэхгүй бол төрийн үйлчилгээ доголдож эхэлдэг.)

- Зарлага, санхүүжилтийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор:
 - Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардал, төрийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө, насны хишиг, боловсролын сангийн зээл, хүүгийн зардлын шилжүүлгийг бүрэн санхүүжүүлж байна.

(Хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнд эдийн засаг сэргэх хандлагатай байгаа тул 2018 оноос эхлэн тэтгэвэр тэтгэмжийг инфляц, үнийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн)

Мөнгөний бодлогын чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүллээ. Тухайлбал:

- Валютын нөөцийг нэмэгдүүлж, ханшийн уналтыг зогсоох зорилгоор:
 - Монголбанк 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 5.83 тонн алт худалдан авч, гадаад валютын нөөцийг ойролцоогоор 145 сая ам.доллараар нэмэгдүүлэх,
 - валютын ханшийг чөлөөтэй, уян хатан тогтох нөхцөлийг бүрдүүлэхээр хөтөлбөрт заасны дагуу Валют арилжааны цахим талбарыг /платформ/ нэвтрүүлж, валютын захын хүртээмж, ил тод, нээлттэй байдал нэмэгдүүлэх.
- Макро эдийн засгийн тэнцвэрийг сайжруулж, эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих хүүгийн бодлого хэрэгжүүлэх зорилгоор:
 - ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк мөнгөний бодлогыг зохих түвшинд чанга барих үүрэг хүлээсэн тул гадаад худалдааны ашгийг нэмэгдүүлж, гадаад улс орнууд, донор байгууллагуудаас эх үүсвэр орж ирэх нөхцөл бүрдүүлэх замаар бодлогын хүүг бууруулах орон зай гаргалаа. Иймд Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2017 оны 6 дугаар сарын ээлжит хуралдаанаараа мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 12 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Уг шийдвэр нь цаашид зээлийн хүү буурах, бизнесийн зардал буурахад түлхэц болно гэж үзэж байна. Жишээлбэл, 2013 оны 6 дугаар сард бодлогын хүүг 1 нэгжээр бууруулж 10.5 хувьд хүргэхэд 18.5 хувьтай байсан арилжааны банкны зээлийн хүү 1.2 нэгжээр буурч 17.3 хувь болж байсан байна.
- Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийг тогтвортой байлгах чиглэлээр:
 - 2017 оны 1 дүгээр сард төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш 2459.44 байсан бол макро эдийн засгийг тогтворжуулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж чадсанаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарч 2360 төгрөг болоод байна. Иймд бензин шатахууны онцгой албан татварыг

үе шаттай нэмэгдүүлэхэд бензин, шатахууны жижиглэнгийн үнэ төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул өргөн хэрэглээний барааны үнэд огцом өөрчлөлт орохооргүй байна.

- Төв банкны бие даасан байдлыг бэхжүүлж, эрх зүн орчныг сайжруулах зорилгоор:
 - Төв Банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүд нь бодлогын шийдвэр гаргахад санал өгөх эрхтэй оролцох, банкны хяналтын тодорхой асуудлуудыг хамтын шийдвэрээр шийдвэрлэх нөхцөл бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авлаа.

Мөн санхүүгийн салбарыг дэмжих чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүллээ. Тухайлбал:

- Хугацаа нь тулсан байсан 580 сая ам.долларын бондын төлбөрийг хийх, өрийн хямралд орох эрсдлийг бууруулах зорилгоор:
 - Хөтөлбөрийн нөлөөгөөр Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, Засгийн газрын гадаад бондын хүү буурснаар 2016 оны 12 сард дуудагдаж байсан 550 сая ам.долларын зээл, 2017 оны 3 дугаар сарын 580 сая ам.долларын бондын төлбөр, 2017 оны 8 сард хугацаа дуусан дуудагдах 2 тэрбум шахам ам.долларын Хятадын ардын банкны своп зэргийг шийдвэрлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Ийнхүү ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын зээлжих зэрэглэл буурахаас сэргийлж, цаашид зээлжих зэрэглэл нэмэгдэн, хөрөнгө оруулалтын орчин сайжрах суурийг бүрдүүллээ.
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар тухайн банк засаглалын болон зээлийн үйл ажиллагааны хувьд улс төрөөс хараат бус, бие даан ажиллах, зөвхөн арилжааны үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор:
 - Хөгжлийн банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг батлуулж, Хөгжлийн банканд 2011-2016 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд аудитын шалгалт хийлгэх ажлыг зохион байгууллаа.
 - Аудитын шалгалтын дүн, хөгжлийн банкны санхүүгийн байдлыг банкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна.
- Стандарт энд “Пүүрс”, “Фитч”, “Мүүдис” агентлагууд манай улсын зээлжих зэрэглэлийг үнэлж байгаа бөгөөд Монгол Улс 2007-2013 оны хооронд “ВВ-” үнэлгээтэй байсан бол өнгөрсөн Засгийн газрын үед удаа дараалан түвшин буурч, түүхэндээ хамгийн муу үзүүлэлт буюу “Саа1-” үнэлгээтэй болсон. Бид санхүүгийн сахилга батыг сайжруулж, хяналтгүй явсан төсвүүдийг нэгтгэх, хэмнэлтийн горимд шилжин, зардлаа хасах, орлогоо нэмэгдүүлэх, мөн ОУВС-тай хамтран хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсний үр дүнд Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтвортой болж, цаашид өсөх хандлагатай боллоо.

ДӨРӨВ. ДУНД ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

- ОУВС-ийн хөтөлбөрт Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд тогтвортой хадгалах хүрээнд эдийн засгийг төрөлжүүлж, эрсдэл даах чадвартай болгохыг зөвлөсөн бөгөөд ОУВС-аас “урт хугацаанд бодитой өрсөлдөх чадвартай, Монгол Улсын стратегийн чухал салбарууд бол хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбар” гэж үзэж, эдгээр салбарыг хөгжүүлэх нөөц бололцоог бүрэн дайчлахыг чухалчилсан.
 - Иймд Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарт түшиглэн эдийн засгийг төрөлжүүлэх буюу Атрын 3 дугаар аяныг үргэлжлүүлэх, мах, сүүний анхдугаар аяныг эхлүүлэх, энэ хүрээнд улсын хэмжээнд 12 мах боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөснөөс Өвөрхангай, Увс аймгуудад мах боловсруулах үйлдвэрийн шав тавьж, барих ажлыг эхлүүлээд байна.
 - Мөн хуурай сүүний үйлдэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх бодлогыг баримталж байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хорио, цээргүйгээр экспортлох нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд монгол малыг эрүүлжүүлэхээр Оросын Холбооны Улсын мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байна.
- Нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах, эдийн засгийн өсөлтийн үр шимийг иргэн бүрт хүргэх зорилгоор Азийн хөгжлийн банк, Дэлхийн банктай хамтран эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр стратегийг тодорхойлоод байна.
- ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, Тавантолгойн төмөр зам, цахилгаан станцын зэрэг томоохон төслүүдийн яриа хэлэлцээрийг үр дүнтэй болгоход түлхэц болно. Эдийн засгийг төрөлжүүлэх томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр дөрвөн жилийн хугацаанд 130 орчим мянган иргэнийг тогтвортой ажлын байраар хангана.
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас манай улсад үзүүлэх хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламжийг бүхэлд нь гэр хорооллын дахин төлөвлөлтөд зарцуулахаар шийдвэрлэлээ. Ингэснээр иргэдээ орон сууцжуулах, агаарын бохирдлыг бууруулах улмаар хотын хөгжлийг дэмжих боломж бүрдэнэ.

ТАВ. ОУВС-ИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ҮР ДҮН

1. **Эдийн засгийн уналтыг зогсоож, тогтвортой өсөлтийн суурийг тавилаа.** 2012 онд 17 хувь хүрч байсан эдийн засгийн өсөлт уруудсаар 2016 оны 3 дугаар улирлын байдлаар – (хасах) 1.6 хувьд хүрч эдийн засаг агшиж эхэлсэн. Үүнийг засч залруулах ажлыг цаг алдалгүй, шуурхай хэрэгжүүлж эхэлснээр эдийн засаг аажмаар сэргэж 2016 оны эцэст 1.2 хувийн өсөлт, 2017 оны эхний улирлын байдлаар 4.2 хувийн бодит өсөлт гарлаа. Бид унаж байсан эдийн засгийг 3 улирлын дотор өсөлтийн хандлага руу орууллаа.

- 2. Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондын төлбөр, Чингис бондын 500 сая ам.долларын төлбөр гэх мэт хугацаа тулсан, томоохон өр төлбөрийн үүрэг тулж ирсэн үед валютын нөөцийг нэмэгдүүлж чадлаа.** 2012 онд 4 тэрбум ам.доллар байсан Гадаад валютын нөөцийг шавхаж, үүний дээр нэмж Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын банкнаас своп хэлцлээр 2 тэрбум шахам ам.доллартай тэнцэх юанийг зээлж авч хэрэглэснээр үндсэндээ гадаад валютын цэвэр нөөц ХАСАХ болж, Үндэсний аюулгүй байдалд аюул учраад байв. Жил тутам 1 тэрбум ам.доллараар багасч байсан валютын нөөц 2017 оны 2-р улиралд 2013 оноос хойш анх удаа нэмэгдэж эхэллээ. Цаашид 2020 он гэхэд гадаад валютын албан нөөцийг дахин 4 тэрбум ам.долларт хүргэж, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн аюулгүй байдлыг баталгаажуулна.
- 3. Валютын ханшийн уналтыг зогсоож, иргэдийн худалдан авах чадварыг хамгаалж чадлаа.** Их хэмжээний интервенц хийх замаар тогтоон барьж байсан ханшийг цаашид барих нөөцгүй болж, 2016 оны 11 дүгээр сард төгрөгийн ам. доллартай харьцах зах зээлийн ханш 2600 орчим төгрөгт хүрсэн. Засгийн газраас валютын орох урсгалыг сайжруулж, валютын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулж, макро эдийн засгийг тогтворжуулах, төлбөрийн тэнцлийг дарамтыг бууруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх бодлого амжилттай хэрэгжүүлсний үр дүнд 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2360 орчим төгрөг болж буураад байна.
- 4. Засгийн газар байгуулагдсаны дараа бие даасан 4 төрлийн төсвийг нэгтгэн, Улсын Их Хурал болон ард түмний хяналтад оруулж, төсвийн сахилга батыг сэргээн тогтоолоо.** 2012-2016 онд Улсын Их Хурлаар баталдаг Улсын төсвөөс гадна (Монголбанк, Хөгжлийн банк, Концесс гэсэн) 3 өөр төсвийг бий болгож, Улсын Их Хурлын болон ард түмний хяналтгүйгээр ихээхэн хэмжээний хөрөнгийг дур мэдэн зарцуулж ирсэн байна.
 - Монголбанк үнэ тогтворжуулах хөтөлбөр, Сайн хөтөлбөр, компаниудад шууд зээл олгох зэргээр 7 их наяд гаруй төгрөгийг мөнгө хэвлэж эдийн засагт нийлүүлэх замаар санхүүжүүлсэн.
 - Концесс нэрээр 2 их наяд гаруй төгрөгийн гэрээ хэлцлийг байгуулж, улсад их хэмжээний өрийн дарамт бий болгосон.
 - Хөгжлийн банкны гадаад зах зээлээс зээлж авсан арилжааны нөхцөлтэй зээлийг эргэн төлөгдөх боломжгүй төслүүдэд зарцуулж, үр ашиггүй зарцуулсан.
- 5. Монголбанкны дур мэдэн мөнгө хэвлэн хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдийг зогсоож, Засгийн газарт шилжүүлэн, төсвийн бүрэлдэхүүнд тусгав.** Монголбанкны үйл ажиллагааг хуульд нийцүүлж, цаашид Төв банкны хууль тогтоомжийг сайжруулах бэлтгэлийг хийж байна.
- 6. Хөгжлийн банк алдагдалд орж, дампуурах нөхцөлд орсон байсныг цэгцэлж, Хөгжлийн банкыг үндсэндээ дахин шинэчилж байгуулав.**
 - Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн нийгмийн шинж чанартай, арилжааны биш төслүүдийг улсын төсөвт шилжүүлж, банкны балансыг цэвэрлэв.

- Хугацаа нь тулсан байсан 580 сая ам.долларын бондын төлбөрийг Засгийн газрын бондоор төлж барагдуулав.
- Банкны дүрмийн санг 1 их наяд төгрөгөөр нэмж, цаашид тогтвортой ажиллан эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжийг бүрдүүлэв.
- Хөгжлийн банкны хуулийг шинэчилж, олон улсын тэргүүн туршлагыг хэрэгжүүлж эхлэв. Цаашид зөвхөн эдийн засгийн үр ашигтай, хөгжлийн төслийг санхүүжүүлж ажиллана.

7. 2016 оны төсвийн алдагдал ДНБ-ийн 20.6 хувь болохоор байсныг төсвийн тодотгол хийн, зардлыг хасах болон зарим хөтөлбөрийг зогсоох замаар төсвийн алдагдлыг ДНБ-ийн 15 хувь болгон бууруулсан.

- Төсвийн алдагдлыг өндөр хүүтэй арилжааны зээлийг дотоод гадаадаас авч санхүүжүүлж байснаар зөвхөн 2016 онд төсвийн алдагдлыг 3.6 их наяд төгрөгийн өрөөр санхүүжүүлсэн байна. Өмнө авсан эдгээр зээлийн зөвхөн хүүгийн зардалд 1 их наяд төгрөг буюу төсвийн орлогын 5 төгрөг тутмын 1 төгрөгийг зээлийн хүүд төлж байна.
- Төсвийн алдагдлыг цаашид 2017 онд ДНБ-ийн 10.4%, 2018 онд 9.5% зэргээр бууруулж 2020 онд ДНБ-ийн 5.1% болгон бууруулна.

8. Өрийн тогтвортой байдлыг бий болгов. 2012 оны сонгуулийн өмнө ДНБ-ийн 30 гаруйхан хувь байсан улсын өрийг 2016 онд ДНБ-ийн 70 гаруй хувьд хүргэсэн. Мөн жил бүр 3 их наяд төгрөгөөс доошгүй өрийг нэмэгдүүлж байх хүнд нөхцөлд орсон төсвийг өмнөх Засгийн газраас өвлөж авсан.

- Өмнөх Засгийн газрын төсвийн бодлогыг үргэлжлүүлэн явуулахад 2017 оны дунд гэхэд Өрийн тогтворгүй байдалд орох, Монгол Улс өр төлбөрөө төлж чадахгүй дефолт буюу дампуурах нөхцөлд орохоор байв. Цаашлаад үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тусгаар тогтнолд ноцтой аюул учрах эрсдэлд байсан.

9. Төсөв болон мөнгөний зохистой бодлого, эдийн засгийг сэргээх бодлого, олон улсын байгууллагуудын дэмжлэг, хамгийн гол нь Засгийн газрын хатуу ч гэсэн зөв шийдвэртэй бодлогын дүнд дефолт буюу дампуурлын тулсан аюулыг зайлуулав.

- 2016 оны 12 сард дуудагдаж байсан 550 сая ам.долларын зээл, 2017 оны 3 дугаар сарын 580 сая ам.долларын бондын төлбөр, 2017 оны 8 сард хугацаа дуусан дуудагдах 2 тэрбум шахам ам.долларын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын банкны своп зэргийг шийдвэрлэв.
- 2021 он гэхэд улсын өрийг ДНБ-ийн 60 хувиас бага түвшинд хүргэж, цаашид үргэлжлүүлэн бууруулна.

10.Зээлийн хүүг бууруулав. 2016 оны 5 сард Засгийн газрын гадаад бондын хүү 10.875%, дотоод бондын хүү 17 хувь болж, хувийн хэвшлийн гадаад зээлийн хүү 15% орчим, дотоод зээлийн хүү 25% орчим болж байв.

- 2017 оны 6 сарын байдлаар Засгийн газрын гадаад бондын хүү 6.5%, дотоод бондын хүү 12% болж буурлаа.
- цаашлаад хувийн хэвшлийн зээлийн хүү эрс буурч, арилжааны банкны хүү дунджаар 16% орчимд хүрч, бизнесийн зардал, дарамт буурч байна.

11.Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээв. 2011-2012 онд ДНБ-ийн 20 орчим хувь байсан Гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс татарч Монгол Улсаас хөрөнгө зугтаж, гадагшилж эхэлсэн байв.

- Эдийн засгийн зөв, тууштай бодлогын дүнд гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэх хандлагатай байна.
- Эдийн засагт их хэмжээний эрсдэл үүсч, тодорхойгүй байдал бий болсноос 2016 оны дунд үе гэхэд гадаадын хөрөнгө оруулалтаас гадна манай дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулалт хийхгүй болж ирсэн. Томоохон үйлдвэр барихаар зорьж байсан үндэсний үйлдвэрлэгчээс эхлээд, дэлгүүр лангуу ажиллуулдаг, наймаа арилжаа хийдэг иргэд хүртэл валютын ханшийн савалгаа, эдийн засгийн уналтаас болж шинээр төсөл, бизнес, арилжаа эхлэхгүй хойшлуулж байв.
- 2016 оны сүүлийн улирал, 2017 оны эхний хагаст бий болсон эдийн засгийн өсөлт, тогтворжилт, төр засагт итгэх итгэл сэргэсний дүнд дотоодын бизнесийн идэвхжил эрс сэргэж, шинээр олон бизнес эхэлж, зогссон олон бизнес дахин эхэлж, олон ажлын байр хувийн хэвшилд бий болж байна. Эдийн засгийн өсөлт, бизнесийн идэвхжлийг даган иргэдийн орлого өсч, аж ахуйн нэгжүүд ашигтай ажиллаж эхэллээ.

12.Иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, шинээр ажлын байр бий болж байна.

- Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүй иргэдийн тоог 20 хувиар буурууллаа. 2016 оны 1 дүгээр улиралд ажилгүйдлийн түвшин 11.6 хувьд хүрсэн, ажилгүй иргэдийн тоо 143.0 мянга болсон байв. Засгийн газрын хэрэгжүүлсэн макро эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг бий болгох бодлогын үр дүнд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ажилгүй иргэдийн тоо 115 мянга, ажилгүйдлийн түвшин 9.1 хувь болж тус тус буураад байна.
- Дампуурч, банкны зээлээ төлж чадахгүй хаагдсан олон бизнес, аж ахуйн нэгж буцан сэргэж, өр зээлээ барагдуулж байна. 2016 онд банкууд дахь чанаргүй зээл нийт активын 9.5% болж өссөн байсан нь буурч 2017 оны 4 дүгээр сарын байдлаар 8.5% орчим боллоо.

13.Экспортыг нэмэгдүүлж, гадаад худалдааны нөхцөлийг сайжрууллаа. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын

Засгийн газартай идэвхтэй яриа хэлцэл хийсний дүнд нүүрсний экспортыг эрс нэмэгдүүлэв.

- Нүүрсний салбарын хамгийн том олборлогч, экспортлогч Эрдэнэс тавантолгой компанийн өмнө үүсээд байсан өр зээлийн асуудлыг бүрэн шийдвэрлэснээр тус компанийн санхүүгийн байдал сайжирч, үйл ажиллагаа эрчимжсэн.
- Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ажлын цагийг уртасгах, тээвэрлэлтийн замыг сайжруулах зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэв.
- Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2017 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 42 хувиар өссөн бол гадаад худалдааны ашиг оны эхний 5 сард 1 тэрбум ам.долларт хүрлээ. Энэ жил экспортлох нүүрсний хэмжээ 30 сая тонн-д хүрэх боломж бүрдэж байна.

14. Төсвийн орлого 2016 оны 11 дүгээр сараас хойш сар дараалан биелэв. Төсвийн санхүүжилтийг цаг хугацаанд нь санхүүжүүлдэг боллоо.

- Өмнөх Засгийн газрын үед хийсэн ажил, нийлүүлсэн бүтээгдэхүүнийхээ санхүүжилтийг авч чадахгүй олон сар, жил дамнах байдал хавтгайрсан байсныг зогсоож, Засгийн газар төлбөрөө цаг тухайд нь, хоцроохгүй чирэгдүүлэхгүй хийх горимд шилжлээ.
- Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг олон сараар олгохгүй хоцроох, тухайн жилийн санхүүжилтийг бүрэн олгодоггүй байсныг зогсоов. 2013-2016 оны дунд хүртэл орон нутгийн хөгжлийн санд олгох хөрөнгийн 80 орчим хувийг л олгож, түүнийгээ хугацаа хоцруулан өгч байсныг, 2016 оны 11 сараас эхлэн сар бүрт нь 100% олгож байна.

ЗУРГАА. “ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ ДОНОРУУДЫН САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ

ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжих болсноор гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, олон улсын банк санхүүгийн байгууллага, 2 талт хамтын ажиллагааны хүрээнд олгож буй хөгжлийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

Үүний нэг илрэл нь Бүгд Найрамдах Австри, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Энэтхэг зэрэг хоёр талт түншлэгч орнуудаас зогсонги байдалд ороод байсан хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрүүдийг батлах, зээлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тохиролцсон төслүүдийн санхүүжилтийг үргэлжлүүлэхээ зарлаад байна.

I. ДЭЛХИЙН БАНК

ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн багцын хүрээнд Дэлхийн банк “Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөгжлийн бодлогын хөтөлбөр”-ийг 3 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн гол зорилго нь “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих, төсвийн тогтвортой байдлыг сайжруулж,

сахилга батыг бэхжүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах, нэгдмэл байдлыг бий болгох, нийгмийн халамжийн хөтөлбөрийг зорилтот бүлэг рүү чиглүүлэхэд зориулж 440 сая ам.долларын санхүүжилт олгоно.

II. ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ-ЖАЙКА

Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлэх “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн санхүүжилтийн багцын хүрээнд Япон Улсын Засгийн газраас 850 сая ам.долларын санхүүжилтийн хөгжлийн бодлогын зээлийг төсвийн дэмжлэг байдлаар 3 жилийн хугацаанд олгоно.

III. АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 2017-2020 онд нийт 600 сая ам.долларын санхүүжилт бүхий төсвийн дэмжлэгийг үе шаттайгаар олгохоор тохироод байгаа билээ.

Энэ хүрээнд 2017 онд Азийн хөгжлийн банктай хамтран эдийн засгийн хүндрэлийн үед нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 150 сая ам.долларын санхүүжилт бүхий “Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр-2”-ийг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, банкуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанаргүй зээлийг шийдвэрлэх механизмыг нэвтрүүлэх, хяналт тавих механизмыг сайжруулах, шаардлагатай санхүүжилтийн хэмжээг нөхөх зорилгоор 100 сая ам.долларын санхүүжилт бүхий “Банкны салбарыг нөхөн сэргээх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлэхээр тохирон, хөтөлбөрүүдийн Зээлийн хэлэлцээрүүдийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулаад байна.

IV. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (ЭЗХХАС)-гаас 2017-2019 онд авах 500 сая ам.долларын зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

Тус зээлийн жилийн хүү 0.2% ба зээл эргэн төлөх хугацаа 30 жил, үүнээс зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 10 жил байна. Энэхүү зээл нь 46.3 хувийн хөнгөлөлтийн түвшинтэй байгаа бөгөөд Монгол Улсын Өрийн удирдлагын тухай хуулийн ангиллаар нэн хөнгөлөлттэй зээлийн ангилалд хамаарч байна. Зээлийн хэлэлцээрийг ойрын хугацаанд хийхээр төлөвлөж байгаа ба санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг энэ оны 3 дугаар улиралд байгуулахаар төлөвлөж байна.

--oo0oo--